



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/113

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3.2, нийслэлийн Засаг даргын "Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай" 2016 оны А/635 дугаар захирамж, газрын Дүрмийн 2.5.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. Тус газрын албан хаагчдын "Ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолт", байгууллагын дүрмийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Энхтүвшин	Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд:	Д.Ганболд	Захиргааны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Э.Батжаргал	Бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Г.Гансүвд	Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Нарийн бичгийн дарга:	Б.Жаргалан	Хүний нөөц, аялал жуулчлалын байгууллага хариуцсан мэргэжилтэн

2. Төрийн албаны зөвлөлөөс баталсан загвар, зааврын дагуу ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж 2017 оны 01 дүгээр сарын 18-ны дотор батлуулахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Энхтүвшин/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан тус газрын 2016 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/89 дүгээр тушаал хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.БАТСҮХ